

ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Улаанбаатар хот
2001 он

**НИЙСЛЭЛ ХОТЫН СОНГИНОХАЙРХАН, БАЯНЗҮРХ ДҮҮРГҮҮДЭД ХӨДӨӨ
ОРОН НУТГААС ИРЖ, ЗОХИХ ЗӨВШӨӨРӨЛ БҮРТГЭЛГҮЙ ОРШИН СУУЖ
БУЙ ИРГЭДИЙН ТАЛААР ХИЙСЭН СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

НЭГ: Судалгааны зорилго, хамрагдсан дүүрэг, хороодод судалгаа

явуулсан арга хэлбэрийн талаар.

Хөдөө орон нутгаас нүүж ирж Нийслэл хотод зохих зөвшөөрөл, бүртгэлгүй оршин сууж байгаа иргэдийг судлан бүртгэж, тэдний нийгэм ахуйн байдал, амьжиргааны түвшин, бүртгүүлж, оршин суух зөвшөөрөл авч чадахгүй байгаа шалтгааныг тогтоож, дүгнэлт хийж, санал зөвлөмж боловсруулж, холбогдох төр захиргааны байгууллагад тавьж, асуудлыг шийдвэрлүүлэх, мөрдөгдөж буй хууль тогтоомж, дүрэм зааврыг боловсронгуй болгох, хүний эрхийн үндсэн зарчимд нийцүүлэхэд уг судалгаа чиглэгдсэн болно.

Зөвшөөрөлгүй оршин суугчид харьцангуй их байдаг Сонгинохайрхан, Баянзүрх дүүргийг сонгон авч, энэ дүүргүүдийн 37 хороодын 4754 өрхийн 18665 хүнийг хамруулан судалгааг хийсэн болно. Энэ нь хоёр дүүргийн бүх хороодын 90.2 хувь, зөвшөөрөлгүй оршин суугчдын /дүүргүүдийн 2002 оны 1 дүгээр сард хийсэн шалгалтаар тогтоогдсон зөвшөөрөлгүй оршин суугчдын/ 60.6 хувийг хамарсан болно. Иймд судалгаанаас гарсан дүгнэлт нь бодит байдалд нийцсэн байх бүрэн магадлалтай гэж үзэж байна.

Судалгаанд холбогдох дүүргүүдийн хороодын Засаг дарга болон хэсгийн дарга нар туслалцаа үзүүлсэн ба Сонгинохайрхан дүүрэгт хамтарсан удирдамжаар шалгалт явуулж, хороодын зарим ажилтнуудад зохих урамшуулал өгсөн.

Судалгааг .-3 асуулт бүхий судалгааны маягт гаргаж, зөвшөөрөлгүй оршин сууж байгаа өрхүүдээр орж харилцан ярилцаж, судалгааны хүснэгтийг бөглөж, хороод дүүргүүдээр нэгтгэж, иргэдийн оршин суух эрхтэй холбоотой хууль тогтоомж, дүрэм зааврыг судлах, тэдгээрийн амьдрал практикт хэрэглэгдэж байгаа байдалтай танилцах, ИБМУТ, Нийслэлийн Засаг даргын дэргэдэх шилжилт хөдөлгөөн хариуцсан ажилтнуудтай уулзан ярилцах, холбогдох дүн мэдээг авах зэрэг хэлбэрээр хийж, нэгдсэн дүгнэлт гаргав.

ХОЁР. Иргэдийн оршин суух газраа сонгох эрхтэй холбоотой хууль тогтоомж, захиргааны болон орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагаас гаргасан шийдвэрийн талаар.

Монгол улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 18 дахь хэсэгт: Монгол улсын иргэн түр буюу байнга оршин суух газраа сонгох эрхтэй оршин суух

эрхийг үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд зөвхөн хуулиар хязгаарлаж болно гэж заажээ.

Одоогийн байдлаар иргэдийн оршин суух газраа сонгох эрхийг шууд хязгаарласан хууль гараагүй байна. Харин одоо мөрдөгдөж буй ЭБШ хуулиар гэмт хэрэгт холбогдсон этгээдээс байнга буюу түр оршин суугаа газраасаа гадагш явж болохгүй гэсэн баталгааг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч гаргуулж авах эрхтэй байдаг байна.

Монгол улсын Засгийн газрын 1996 оны 47 дугаар тогтоолоор батлагдсан “Иргэдийн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх мэдээлэх журам”-ыг баталжээ.

Экэхүү журмаар “аймгаас аймагт, аймагас нийслэлд шилжих иргэнийн хүсэлтийг шийдвэрлэхдээ зайлшгүй шаардлагатай бол шилжих, шилжүүлэх аймаг, нийслэл харилцан зөвшилцөж болно. Аймаг, нийслэл нь шилжин ирэх иргэнд газар олгох, ажлын байраар хангах, нийгэм ахуйн үйлчилгээ үзүүлэх боломжгүй бол энэ тухай мэдэгдэж, шилжүүлэн авахаас тодорхой хугацаагаар татгалзаж болно” гэж заажээ.

Төр, захиргааны байгууллагууд иргэдийн оршин суух газраа сонгох эрхийг нь чөлөөтэй эдлүүлэх нийгэм, эдийн засгийн нөхцөлийг нь бүрдүүлэх үүрэгтэй бөгөөд тэдний эрхээ хэрэгжүүлэх асуудлыг шилжих, шилжүүлэх аймаг, нийслэлийн зөвшилцөх асуудал болгож, улмаар татгалзаж болохоор дээрх журамд заасан нь Үндсэн хуулийн "... оршин суух газраа сонгох эрхийг... зөвхөн хуулиар хязгаарлаж болно" гэсэн заалттай зөрчилдөж, хүний эрхийг зөрчсөн байна.

Нийслэл хотод шилжин суурьших асуудлыг Нийслэлийн ИТХТ-ийн 1995 оны 69, 2000 оны 46 дугаар тогтоолоор баталсан журмуудаар зохицуулдаг байна.

Нийслэлийн ИТХТ-ээс Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг баримтлан нийслэл хотод шилжин суурьшигч насанд хүрээгүй иргэдээс 25 мянга, насанд хүрэгчдээс 50 мянган төгрөгийн төлбөр авч байхаар журамлажээ.

Хуулийн энэхүү заалт нь Нийслэл хотод хэт төвлөрөл бий болохоос сэргийлж, хуулийн хүрээнд зохицуулалт хийж болно гэснээс бус төлбөр хураамж татах эрх олгоогүй байна.

Татварын ерөнхий хуулиар ч аливаа татвар /албан татвар, хураамж, төлбөр/-тай холбоотой асуудлыг зөвхөн Татварын хуулиар зохицуулна гэсэн заалтыг ч зөрчсөн байна.

Дээрх журмаар төр, захиргаа, нийслэлийн зарим байгууллагын шийдвэрээр нийслэлд албан тушаалд томилогдсон, сонгогдсон хүмүүс болон тэдний гэр бүлийг төлбөрөөс чөлөөлж, шилжин суурьших болсон үндэслэлээр нь ялгаварласан байна. Ингэснээр нийслэлд амьдрахын эрхээр шилжин ирсэн, эсвэл ах, дүү, төрөл саднаа түшиглэж амьдрах гэсэн өндөр настан, тахир дутуу хүмүүс л энэхүү хураамжийг төлөх

болдог байна.

Хэрэв төлбөрөө төлөх чадваргүй бол албан ёсоор бүртгүүлж нийслэлийн иргэн болох эрхээ алддаг байна.

Түүнчлэн энэ журмаар аймгаас шилжихийг хүссэн иргэний өргөдлийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт илгээж, зөвшөөрсөн тохиолдолд л аймаг нь хасалт хийж, шилжихийг нь баталгаажуулдаг байна. Энэ журам нь бараг үйлчилдэггүй, аймгууд ихэвчлэн шууд шилжүүлдэг гэх боловч Говь-Алтай, Дундговь, Хэнтий аймгууд энэ журмыг мөрддөг байна.

Иймээс шилжин суурьшигчдаас төлбөр авч байгаа журмыг хүчингүй болгуулах, зөрчлийг засуулах талаар холбогдох газруудад асуудал оруулах нь зүйтэй гэж үзсэн болно.

ГУРАВ. Нийслэл хотод зөвшөөрөл, бүртгэлгүй оршин суугчдын дунд явуулсан судалгааны дүнгийн талаар.

Нийслэлийн Сонгинохайрхан, Баянзүрх дүүргийн 37 хороонд оршин сууж буй 4754 өрхийн 18665 хүн ам уг судалгаанд хамрагджээ. Тэдний 28.3 хувь нь хүүхэд, 12.9 хувь нь өндөр настан, тахир дутуу хүмүүс, 58.8 хувь нь хөдөлмөрийн чадвартай иргэд байна.

Хөдөлмөр эрхлэлт: Нийт хөдөлмөрийн чадвартай иргэдийн 56.2 хувь нь эрхэлсэн тодорхой ажилгүй байна. Өөрөөр хэлбэл, аль нэг байгууллагад байнга ажил эрхэлж нийгмийн даатгалд хамрагддаггүй байна. Нийслэл хотод бүртгэлгүй учир аль нэг байгууллагад ажилд орох боломж байдаггүй, Нийслэлийн ИТХТ-ээс баталсан журамд ч нийслэл хотод албан ёсоор шилжээгүй хүнийг ажилд авахыг хориглосон, хэрвээ ажилд авсан бол Захиргааны хаиуцлагын тухай хуульд зааснаар арга хэмжээ авахаар заагдсан байна.

Тодруулга: Увс аймгаас нүүж ирсэн гэрээ нүүлгэхэд 300 000 төгрөг байдаг тул хүний гэр гуйж барьсан. Хөдөлмөрийн чадвартай 5 хүнтэй. Хөдөөгийн паспорттой учир ажил олддоггүй.

Сонгинохайрхан дүүргийн 7 дугаар хорооны иргэн С.Мөнхбат

Иймээс зөвшөөрөлгүй оршин суугчдын нэлээд хэсэг нь албан бус секторт өөрөөр хэлбэл, цай хоол хийж зарах, зах дээр тэрэг түрэх, ачаа зөөх, түлээ нүүрс зарах, хувийн хашаа, байшин засварлах зэргээр хөдөлмөрлөж амьдралаа залгуулдаг байна.

Сурч боловсрох, эрүүл мэндээ хамгаалуулах, нийгмийн үйлчилгээнээс хүртэх эрх: Зөвшөөрөлгүй шилжин суурьшигчдын хүүхдүүд сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуульд хамрагдаж боловсрол эзэмших асуудал хүндрэлтэй

болсон байна. Сургуулийн насны 3449 хүүхдийн 18.3 хувь нь буюу 633 хүүхэд сургууль завсардсан байна. Хөдөө орон нутгаас зөвшөөрөлгүй ирсэн хүүхдүүд танил талынхаа шугамаар ар өврийн хаалгаар ойролцоох сургуульд орж аргагүй нэг хэсэг нь сурч чадахгүйд хүрдэг байна. Захын хорооллуудын ачаалал хэт ихэдсэн нь тэдний сургуульд орох эрхийг хязгаарлах үндэслэл болдог байна.

Тодруулга: Тухайлбал, 67 дугаар сургуулийн нийгмийн ажилтан Ургац, манай сургуульд 680 хүүхдийн хүчин чадалтай боловч 2380 хүүхэдтэй. Хонгил булан тохой бүрийг анги танхим болгоод зарим ангиа хойд цэцэрлэгт хичээллүүлж байна. Анги дүүргэлт 45-50 болсон. ЭнЭ жил 329 хүүхэд нэмэгдсэн. Номын сангаа хүртэл анги болгосон гэж тайлбарлажээ.

Ерөнхий боловсролын сургуулиудын хүчин чадал нь харьяа хороодынхоо зөвшөөрөлтэй оршин суугчдын хүүхдийнхээ тооноос хэт доогуур байдаг тул тэдгээр сургуулиуд зөвшөөрөлгүй иргэдийн хүүхдийг авах сонирхол бага байдаг байна. Хорооноос түр суугч гэсэн бичиг авсан болон хөдөөнөөс ирсэн хүүхдийг сургуульд авах болоход тэднээс түвшин тогтоох шалгалт авдаг журам тогтсон бөгөөд шалгалт өгөөд ихэвчлэн тэнцдэггүй байна.

Харин гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалттай сургуулиуд зөвшөөрөлтэй, зөвшөөрөлгүй хэний ч хүүхдийг авч болно гэсэн зарчимтай боловч мөн л түвшин тогтоох шалгалтыг нь давж гардаггүй байна.

Судалгаанд хамрагдсан хүмүүсээс эмнэлгийн үйлчилгээнд хамрагдаж байгаа эсэхийг нь тодруулж үзэхэд бүх өрхийн 65.9 хувь нь эмнэлгийн үйлчилгээнд хамрагддаг гэж хариулсан байна.

Эдгээр иргэд нь эмнэлгийн үйлчилгээ авдаг гэж хариулахдаа ихэвчлэн өрхийн эмнэлэгтэйгээ холбож ойлгож хариулсан байна. Өрхийн эмнэлгүүд нь амбулаторийн үзлэг, идэвхтэн эргэлт, дуудлага, диспансерын хяналт, урьдчилан сэргийлэх үзлэг, тариа боолт хийх зэрэг үйлчилгээ үзүүлдэг бөгөөд энэ үйлчилгээг бүртгэлтэй бүртгэлгүй иргэд гэж ялгахгүйгээр харьяа хороо хэсгийнхээ газар нутагт оршин сууж байгаа иргэдэд нэгэн адил үзүүлдэг байна. Бүртгэлгүй иргэдийн хувьд эмнэлэгт хэвтүүлж эмчлүүлэх, рашаан сувиллын бичиг авах зэрэг үйлчилгээг авч чаддаггүй байна.

Хорооны бүртгэлгүй иргэдийн өрхийн эмнэлгээр үйлчлүүлсний зардал төсөвт нь орж ирдэггүй бөгөөд харин төсөв нь хасагдахад шууд нөлөөлдөг байна. Тухайлбал, бүртгэлгүй иргэдийн гэртээ төрөх, халдварт өвчнөөр өвчлөх, \ жирэмсний хяналтанд хожуу орох зэрэг үзүүлэлт нь өрхийн эмнэлгийн ажлын үзүүлэлтэд сөргөөр нөлөөлж батлагдсан төсвөөсөө хасуулах үзүүлэлт болдог байна.

Хөдөө орон нутгаас зөвшөөрөлгүй оршин суугчид нийгмийн халамжийн болон элдэв төрлийн хөнгөлөлт, дэмжлэгт хамрагддаггүй байна.

Зөвшөөрөлгүй суугчдын харьяалал ба хугацаа: Судалгаанд хамрагдсан зөвшөөрөлгүй сууж буй өрхүүдийг ирсэн аймгаар нь судалж үзэхэд дор дурьдсан 10 аймгаас илүү олон өрх нүүж ирсэн нь ажиглагдаж байна.

- I Төв аймаг - 714 өрх
- II Өвөрхангай аймаг - 365 өрх
- III Завхан аймаг - 317 өрх
- IV Архангай аймаг - 287 өрх
- V Увс аймаг - 242 өрх
- VI Хэнтий аймаг - 207 өрх
- VII Дундговь аймаг - 197 өрх
- VIII Сэлэнгэ аймаг - 190 өрх
- IX^I Баянхонгор аймаг - 177 өрх
- X Говь-Алтай аймаг - 162 өрх

Үүнээс үзвэл, сүүлийн жилүүдэдгэн зудын аюулд жил дараалан өртөж байгаа аймгуудаас харьцангуйгаар олон өрх айл нүүж ирж байгаа нь харагдана. Түүнчлэн Хотын захиргаанаас гаргасан албан ёсоор шилжиж ирсэн иргэдийн тоо мэдээнээс харсан ч энэ дүгнэлт батлагдаж байна.

2000 оны мэдээгээр Төв аймгаас 2234, Увс аймгаас 2165, Завхан аймгаас 2074, Говь-Алтай аймгаас 1181, Дархан-Уул аймгаас 1132, Ховд аймгаас 1051 хүн албан ёсоор шилжиж ирсэн нь хамгийн их байна. Энэ үзүүлэлт сүүлийн хэдэн жилд нэлээд тогтвортой харагдаж байна.

Зөвшөөрөлгүй оршин суугч өрхүүдийг ирсэн хугацаагаар нь ангилж үзвэл 1 жил хүртэл хугацаагаар буюу 2001 онд нүүж ирсэн өрх 52.6 хувь, 1-2 жил болсон буюу 2000 онд нүүж ирсэн өрх 22.4 хувь, 2-оос дээш жил болсон өрх 25 хувийг тус тус эзэлж байна. Үүнээс үзвэл, зөвшөөрөлгүй суугчдын тоо 2001 онд эрс харагдаж байна. Харин Хотын захиргаанаас гаргасан мэдээгээр албан ёсоор шилжиж ирсэн өрх, хүний тоо 2001 онд эрс буурсан байна. Тухайлбал, 2000 онд 19482 хүн шилжин ирж байсан 2001 онд 10842 хүн шилжин ирж бараг 2 дахин буурчээ. Эдгээр дүн мэдээнээс үзвэл 2001 оноос эхлэн шилжилтийн хураамж 2 дахин нэмэгдсэнээс албан ёсоор шилжигсдийн тоо 2 дахин буурч, зөвшөөрөлгүй нүүж ирэгсдийн /хураамж төлөхгүйгээр/ тоо эрс өссөн байна гэж үзэхээр байна.

Дүгнэлт, санал, зөвлөмж: Нийслэл хотод албан ёсны зөвшөөрөлтэй болон зөвшөөрөлгүй шилжин ирж суурьшигсдын тоо жилээс жилд өсөн нэмэгдэж, Нийслэл

хотын захын дүүргүүдийн хороодод шилжин суурьшиж байгаа нь тэдний сурч боловсрох, эрүүл мэндээ хамгаалуулах, нийгмийн халамж үйлчилгээнд хамрагдах, газар эзэмших, тусламж дэмжлэг авах эрх нь зөрчигдөөд зогсохгүй үндсэн оршин суугчдын эрх ашигт сөргөөр нөлөөлж, Нийслэлийн төлөвлөлт үйлчилгээнд ихээр нөлөөлөх болжээ.

Хөдөө орон нутагт олон жил дараалан ган зуд болж, малчид амьжиргааны эх үүсвэрээ алдах, тэнд ажлын байр ховор байгаа болон сургууль соёл, эмнэлгийн үйлчилгээний чанар хүртээмж муу байгаатай холбоотой гэсэн дүгнэлт хийж байна.

Нийслэл хотод хүн амын хэт төвлөрөл бий болохоос урьдчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлж буй бодлого тухайлбал, шилжин суурьшигсдаас өндөр хураамж авч зохицуулах гэсэн оролдлого нь эерэг, нааштай үр дүн өгч чадахгүй байна. Харин ямарч бүртгэл, хяналтгүй оршин суугчдын тоо ихэсч, тэд зөвшөөрсөн ч, зөвшөөрөөгүй ч Нийслэл хотод ирж суурьшиж, эмх замбараагүй байдал хавтгайрах хандлагатай болсон байна.

Харин ч өндөр хураамж тогтоосон нь албан тушаал дэвшсэн, мөнгө хөрөнгөтэй хүн Нийслэл хотын иргэн болж бүртгүүлж чаддаг, ажилд орох амь зуухын тулд орж ирсэн хөрөнгө, орлого багатай, олон ам бүлтэй, амьдралын гачигдалтай иргэд “зөвшөөрөлгүй иргэд” хэмээх бүлэгт багтаж, эрх ашиг нь зөрчигдөж, нийгмийн халамж үйлчилгээнээс гадна орхигддог байна.

Иймд судлгааны дшнгээс үндэслэн доорхи арга хэмжээг авах нь зүйтэй гэж үзсэн болно.


1. Шилжин суурьшигч иргэдээс авч байгаа төлбөрийг хүчингүй болгож, шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх мэдээлэх журмаа шинэчлэн боловсруулж мөрдөх талаар Нийслэлийн ИТХТ-д Хүний эрхийн Үндэсний Комиссын зөвлөмж гаргах.

2. Судалгааны дүнгийн талаар Монгол улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газарт танилцуулга бичиж, шилжин суурьших хөдөлгөөнийг зохицуулах, Нийслэл хотод хүн амын хэт төвлөрөл бий болохоос урьдчилан сэргийлэх асуудлыг Монгол улсын Үндсэн хууль, Олон улсын гэрээ, конвенцид заасан хүний эрхтэй нягт уялдуулан, улсын чанартай нэгдсэн бодлого боловсруулахыг санал эолгож байна.

НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ, СОНГИНО ХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗӨВШӨӨРӨЛГҮЙ ОРШИН СУУЖ

БУЙ ИРГЭДИЙН ТАЛААР ХИЙСЭН НЭГДСЭН СУДАЛГАА

	Хорооны дугаар	Өрхийн тоо	Хүний тоо	Үүнээс			Сургуулийн насны хүүхэд хэд	Үүнээс		Тэтгэвэр тэтгэмж авдаг	Амжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлогогүй буюу орлогогүй иргэд	Хувийн хашаатай өрх	Хувийн гэр байшинтай өрх	Газар эзэмших зөвшөөрөлтэй өрх	Малтай өрх	Усан хангамжтай өрх	Эмнэлгийн үйлчилгээтэй өрх	Хогны үйлчилгээ авдаг өрх
				Хөдөлмөрийн чадвартай	Хөдөлмөр эрхэлдэг	Өндөр настай тахир дутуу иргэд хэд		Сургуульд сурдаг хэд	Сургууль завсардсан									
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18
БЗ		1684	6246	3494	1825	337	1278	1094	184	159	924	75 2	1257	340	12	1612	1282	1595
СХ		3070	12419	6239	2434	825	2755	2355	449	553	1967	16 40	2042	655	26	2708	1852	2188
Бүгд		4754	18665	9733	4259	1162	4033	3449	633	712	2891	23 92	3299	995	38	4320	3134	3783



БЗ
СХ
Бүгд

Шугамын радиотой өрх	Телевизортой өрх	Шилжих болсон шалтгаан өрхөөр				Аймгийн шилжүүлэггүй өрх	Шилжиж ирсэн хугацаа			Бүртгүүлээгүй шалтгаан			Орлого тодорхойгүй буюу орлогыг бичээгүй
		Ажил хийж амьдрахаар ирсэн	Ах,дүү хүүхдийнхээ тусламж дэмжлэг авахаар ирсэн	Оюутны гэр бүл	Бусад		1 жил хүртэл болж байгаа	1-2 жил болж байгаа	2 ба түүнээс дээш жил болж байгаа	Шилжилтийн хураамж төлөх боломжгүй	Аймгаас шилжүүлэг аваагүй	Бусад шалтгаантай	
19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30	31	32
288	1138	1288	178	81	131	1098	1016	404	258	1209	976	169	474
262	2044	1661	606	213	575	1649	1487	650	906	1660	937	568	570
490	3182	2949	784	294	706	2747	2503	1060	1164	2869	1913	737	1044

ОРШИЛ

Хүний эрхийн олон улсын билл, Монгол улсын Үндсэн хуульд “Хүн оршин суух газраа чөлөөтэй сонгох эрхтэй” хэмээн заасан байдаг. Энэхүү эрхийн хэрэгжилтийн төлөв байдлыг судлах зорилгоор нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 6,7,8,15,16-р хороонуудад хөдөө орон нутгаас нүүж ирж, Улаанбаатарт бүртгэлгүй амьдарч байгаа өрхүүдээр явж судалгаа хийлээ. Тус судалгаагаар эдгээр өрхүүдийн нийслэлд нүүж ирэх болсон болон бүртгүүлэхгүй байгаа шалтгаан, бүртгэлгүйгээс улбаалаад тэдний амьдралд тохиолдож буй бэрхшээлийг тодруулах гол зорилготой байсан.

Судалгаа хийсэн аргачлал. судалгаанд хамруулсан хүрээ

Судалгаа хийх явцдаа асуулга-ярилцлагын арга, бүлгийн ярилцлага, баримт материалд дүн шинжилгээ хийх гэх мэт арга барилыг ашиглалаа. Судалгааны явцад 5 хорооны нийт 140 өрхөөр орж, хөдөө орон нутгаас нүүж ирсэн, бүртгэлгүй өрхийн 14.8% буюу 104 өрхөөр биечлэн явж, анкетын асуулга авсан. Мөн түүнчлэн хороодын ИТХ-ын дарга, Засаг дарга, зохион байгуулагч, нийгмийн ажилтан, хэсгийн дарга, өрхийн эмч, сувилагч, ерөнхий боловсролын сургуулийн захирал, хичээлийн эрхлэгч, нийгмийн ажилтан, багш, сурагчид, жирийн иргэд гэх мэт 40 орчим хүмүүстэй ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага хийж, уулзаж ярилцсан. УИХ-ын гишүүн Баасанжавын 7 хорооны сонгогчидтойгоо уулзсан уулзалтанд оролцож, тус хорооны бэрхшээл, хүндрэлийн талаар иргэдийн ярьж байгаа зүйлийг сонсож, ажиглалт хийлээ.

Сонгинохайрхан дүүргийн 6,7,8,15,16-р хороодод судалгаа хийсний үр дүнд дараах байдлаар судалгааны тайланг бичлээ. Үүнд:

1. Хорооноос үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээ
2. Хөдөлмөр эрхлэлт
3. ЕБС-ийн хүрэлцээ, сургуульд хамрагдалт
4. Үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө
5. Өрхийн эмнэлгээс үзүүлэх эмчилгээ, үйлчилгээ
6. Шилжин ирэх болсон болон бүртгүүлэхгүй байгаа шалтгаан

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

СУДАЛГААНЫ ДҮНГЭЭС

1. Хорооноос үзүүлэх хөнгөлөлт үйлчилгээ

Хороо нь засаг захиргааны анхдагч нэгж бөгөөд дотроо хэсэгт хуваагддаг. Дунджаар нэг хороо 9 хэсэгтэй байдаг бөгөөд улиралд 12500 төгрөгний урамшуулал бүхий, орон тооны бус хэсгийн даргатай. Хорооны зүгээс хорооныхоо иргэдэд бүх төрлийн төрийн үйлчилгээг үзүүлэх үүрэг зорилготой. Орон сууцны хороодыг бодвол гэр хорооллын хороодын хувьд сүүлийн 10-аад жилд учраад байгаа нэг гол бэрхшээл бол хөдөө орон нутгаас шилжин ирж, бүртгэлгүйгээр амьдарч буй өрхүүдийн асуудал юм. Судалгаанд хамрагдсан гэр хорооллын хороодын нийт өрхийн ойролцоогоор 10 орчим хувьтай тэнцэх хэмжээний хөдөө орон нутгаас шилжин ирсэн бүртгэлгүй өрхүүд эзэлж байна.

Тодруулга:

Манай хороо 1190 өрх, 5500 гаруй хүн амтай. Гэтэл манай хорооны нийт өрхийн 10 гаруй хувьтай тэнцэх хэмжээний өрх бүртгэлгүйгээр амьдарч байна. Нүүж ирсэн бүртгэлгүй өрхийн дийлэнх хувь нь ядуу, нэн ядуу өрх. Тэгэхлээр эндээс манай хороонд ямар хэмжээний ачаалал бий болж байгааг та бүхэн харах байх. Нэг жишээг дурьдахад л гэрэл цахилгааны ачаалал дийлдэхээ больсноос тог ид ачааллын үеэр маш бүдэг болдог. 1 шонгийн модноос 30 хүртэл айл тог авах явдал ч байна. Түүнээс гадна хог, ус гэх мэт үйлчилгээг үзүүлэхэд ч бэрхшээл учруулдаг. Тэр ч байтугай захын хорооллын ихэнх сургуулиудын ачаалал хэд дахин ихэссэн. Эмнэлгийн үйлчилгээ ч мөн адил. Гэвч нэгэнт Монгол улсын иргэн л учир тэдгээр хүмүүст хөнгөлөлт үйлчилгээ үзүүлэх хэрэгтэй. Гэтэл тэд бүртгэлгүй учир ихэнх үйлчилгээнд хамрагдах боломжгүй болж үлддэг. Үнэхээр тэр хүмүүсийг буруутгах аргагүй. Малаа зудад алдсан, хөдөө ямар ч амьдралгүй болоод аргагүйн эрхэнд нүүж ирсэн хүмүүс байдаг.

СХП-ийн 8-о хооонд хийсэн бүлгийн яолилагаас . . .

Хэдийгээр дээрх өрхүүдийн ихэнх нь АБДТ-ээс доогуур орлоготой амьдардаг ч Улаанбаатар хотын бүртгэл байхгүйгээс үүдэж төрөөс үзүүлдэг олон төрлийн хөнгөлөлт үйлчилгээнд хамрагдахгүй үлдэх нь элбэг байдаг юм байна. Тухайлбал өвөлд нүүрс, түлээний хөнгөлөлт, гэрэл цахилгааны төлбөрийн хөнгөлөлт, буцалтгүй тусламж,

хөнгөлөлттэй зээл зэргийг дурьдаж болно.

Тодруулга:

Өнгөрсөн жил гэрэл цахилгааны төлбөрөөс 100 гаруй өрхийг 100 хувь хөнгөлөх ажлыг манай хороо, ЦШСГ-тай хамтран зохион байгуулсан. Гэтэл энэ нь зөвхөн манай хорооны суурин өрхөд хамаарах учир хөдөөнөөс орж ирсэн бүртгэлгүй өрх хамрагдах боломжгүй болж байгаа юм.

Тус хороодын Засаг дарга, зохион байгуулагч, ИТХ-ын дарга, хэсгийн дарга гэх мэт хүмүүстэй уулзаж ярилцахад хөдөө, орон нутгаас шилжин ирэгсэдийн хувьд бэрхшээл их байдаг талаар ярьж байлаа. Ихэнх шилжин ирэгсэд хөдөө ажил байхгүй, зах зээл бараадаж ирдэг, ган, зудад ихэвчлэн малаа алдсан, амьдралын эрхээр ах дүүгээ бараадаж ирцгээдэг. Тэдний хувьд хорооноос үзүүлэх туслалцаа бага байдаг хэдий ч угаас амьдрал хэцүү байгаа ганц нэг айлыг гадны буюны байгууллагын тусламжинд хамруулдаг гэж ярьж байсан. Дээрх бүртгэлгүй айлууд нь ихэвчлэн нийслэлд шилжин орж ирэхэд төлөх төлбөрийг дийлэхгүй ядуу айлууд байдаг бөгөөд нэгэнт нүүгээд ирсэн тохиолдолд буцаж орон нутаг руугаа ч явж чадахгүйд хүрч хаана ч харъяалалгүй болж улам ядуурахад хүрдэг.

Жишээ:

Дорнод аймгийн иргэн Лхагвасүрэн эхнэр 5 хүүхдийн хамт 1.5м*2м жижигхэн түлээний амбаарт амьдардаг. 2-р ангиасаа сургууль завсардсан том хүүгийн хамт /16 настай/ Хархорин зах дээр тэрэг түрэх, шил лааз цуглуулах мэтээр хоногийн хоолоо залгуулдаг. Гэрэл цахилгаангүй, аймгаасаа шилжүүлэг аваагүй. Энэ өрхийн хувьд хороондоо бүртгэлгүй учир хорооноос үзүүлэх хөнгөлөлт үйлчилгээнд хамрагддаггүй.

СХД-ийн 8-р хороо, Нуурын Задгай

Мөн судалгаа хийж явахад 1-р хорооллын Дэнжийн задгай хэмээн нэрлэгдсэн газар амьдарч байгаа айл өрхүүд илүүтэй ихээр бэрхшээлтэй амьдарч байлаа. Тэр ч байтугай аль ч хороонд харъяалалгүй, өрхүүд ч нилээд байсан. Гэвч сонгуулийн үеэр тэднийг хэсгийн зохион байгуулалтад оруулж сонгуульд оролцуулсан бөгөөд газрын тухайд маргаантай байгаа тэдгээр өрх айлуудад нилээдгүй амлалт өгч, сэтгэл зүйгээр нь тоглоод одоо хайхралгүй үлдээжээ. Дээрх дэнжид ус, цахилгаан, хог гэх мэт аль ч

үйлчилгээ байдаггүй. Хувийн усны тэрэгнээс усаа литрийг нь 3 төгрөгөөр худалдаж авч уудаг ажээ. Судалгаа хийж явах явцад дээрх айлуудаар явахад өнгөрсөн зуунд очсон мэт сэтгэгдэл төрж байлаа. Тэд цахилгаангүй учир ТВ үзэж чадахгүй, шугамын радио ч байхгүй, мэдээллээс тасархай амьдарч байна.

Жишээ:

Манай хорооны зүгээс Дэнжийн зэдгайд амьдарч байгаа өрхүүдийг харж, харгалзаж байгаа зүйлгүй. Газар нь зөвшөөрөлгүй газар, тэгээд ч манай хороонд харьяалагддаггүй. Бид нар хүн амын тооллого, баримт бичгийн шалгалтын үеэр л тэрүүгээр явсан. Нийслэл, дүүргээс л тэдний асуудлыг шийдэх байх гэж хүлээж байна. Бид хөөгөөд дийлдэггүй.

СХД-ийн 15-р хорооны зохион байгуулагч Наранцэцэг

Манай хорооны хувьд хойд дэнжийн айлуудаа бүртгэж аваад картжуулсан. Энэ ажлын хүрээнд хэсэг байгуулж, хэсгийн ахлагчийг томилоод байгаа. Бусад хороодод харьяалагдах нутаг дэвсгэрийн айлууд манай хороог бүртгэж байна гэхээр манайд бүртгүүлэх гэж зүтгэдэг. Энэ айлуудын асуудлыг цэгцэлж өгөхгүй бол тэдний амьдрал хүнд байгаа.

СХД-ийн 16-р хорооны Засаг дарга Байгальмаа

Дээрх хоёр жишээ дэнжид амьдарч байгаа хүмүүсийн хувь заяа хаашаа ч хэлбийхэд бэлэн байгааг тод харуулж байгаа юм. Энэ нь одоо хүртэл шийдвэрлэгдээгүйгээс зарим өрх нь хороонд харьяалагдахгүй үлдэж, эрх ашиг нь хохирч байна.

Хороодуудаар явж байхад нийтлэг ажиглагдсан нэг зүйл бол задгай гэсэн нэрийн доор ямар ч үйлчилгээгүй айл өрх элбэг байна. Хөдөө орон нутгаас шилжин ирэгсэд ихэвчлэн 24-ын, 38-ын гэх мэт задгайд хашаа хатгаж буудаг учир тэд цахилгаангүй, ус, хогны үйлчилгээ байхгүй, эсвэл их холоос усаа авах гэх мэт бэрхшээлд илүүтэй өртдөг ажээ. Энэхүү задгай хэмээх газар нь үер усны аюулд өртөх магадлал ихтэй, гуу жалга, уулын орой гэх мэт байрлалын хувьд ч тийм сайнгүй газрууд байна. Хороодуудаас шинээр буусан газруудын зөвшөөрлийн асуудлаа газрын албатай хамтран шийддэг юм байна.

1. Хөдөлмөр эрхлэлт

Хөдөөнөөс шилжин ирсэн нийслэлд бүртгэлгүй амьдарч байгаа эрхүүдийн дунд судалгаа хийхэд нийт 701 өрхөөс 541 буюу 77.2% нь АБДТ- ээс доогуур орлоготой ядуу,

нэн ядуу өрх эзэлж байна. Дээрх айлуудын ядуурлын гол шалтгаан нь хөдөлмөр эрхлэлттэй холбоотой. Учир нь нийт хөдөлмөрийн чадвартай хүн амын 78.6% нь буюу нийт 1209 хүн ажил хөдөлмөр эрхэлдэггүй.

Айлуудаар судалгаа хийж явах явцад тэдэнд тохиолдож буй гол бэрхшээл бол нийслэлд бүртгэлгүй учраас ажил авдаггүй гэж хариулж байсан.

Тодруулга:

Хөдөөнөөс шилжин ирэгсдийн хувьд гардаг нэг бэрхшээл бол тэд ихэвчлэн мэргэжлийн чиг баримжаагүй байдаг. Мэргэжлийн чиг баримжээ олгох төрлийн сургалтанд хамруулах гэхээр нийслэлийн иргэн биш учраас төлбөрийн хөнгөлөлт гэх мэт зүйлд хамрагдаж чадахгүйд хүрдэг. Гэтэл энэ айлууд хоногийн хоолоо арай гэж олдог тул өөрсдөө сургалтын төлбөр төлөх боломжгүй.

Мөн өөр нэг зүйл бол ядуурлыг бууруулах, ажлын байртай болох гэх мэт чиглэлээр хороонд ирж байгаа жижиг, дунд зээлд хамрагдах боломжгүй.

СХД-ийн 8-р хорооны ИТХ-ын дарга Сүхбаатар

Хөдөөнөөс шилжин ирэгсдийн хувьд нэгэнт нийслэлийн бүртгэл байхгүй тохиолдолд хороо, дүүрэг, нийслэлээс иргэдэд үзүүлдэг ихэнх хөнгөлөлт, үйлчилгээнд хамрагдах боломжгүй тул өөрсдөө л асуудлаа шийдэх ганц зам үлддэг. Дээрх хүмүүсийн хувьд амьжиргаагаа залгуулдаг гол хөдөлмөр нь эмэгтэйчүүд ихэвчлэн зах дээр цай хоол зарах, эрэгтэйчүүд тэрэг түрэх, ачаа зөөж, буулгах, хаягдал төмөр, зэс, лааз, шил цуглуулж, тушаах гэх мэт болжээ. Гэвч дээрх хөдөлмөр эрхэлж олж байгаа орлого нь өдрийн хоолоо арай, чамай залгуулахад л хүрэлцдэг гэж хэлж болно. Тэр ч байтугай энэхүү өрхийн хөдөлмөрт сургуулийн насны хүүхдүүд нь хамрагдаж, дээрх хүнд хөдөлмөрт хавсардаг.

1. Ерөнхий боловсролын сургуулийн хүрэлиээ. сургуульд хамаагдалт

Бүртгэлгүйгээр Улаанбаатарт амьдарч байгаа айлуудад тохиолдож байгаа өөр нэг бэрхшээл бол сургууль завсардалт юм. Тус хороодод сургуулийн насны 575 хүүхэд байгаагаас 22 хувь буюу 126 хүүхэд сургууль завсардсан гэсэн тоо байна. Хэдийгээр хороонд түр оршин суугчаар бүртгэгдсэн айлын хүүхдүүдийг сургууль авах ёстой байдаг ч энэ нь зарим талаар зөрчигддэг гэж иргэд ярьж байсан.

Жишээ

Би хэдийгээр 7-р хороонд түр оршин суугчаар бүртгүүлээд охиноо харъяаллын сургууль болох 67-р сургуульд оруулах бичиг хийлгэсэн боловч, энэ бичиг хамаагүй гээд аваагүй учир таньдаг хүний тусламжтайгаар Толгойтын тэнд байдаг сургуульд оруулсан. Энэ сургууль нь хол байдаг, манайх автобусны буудлаас хол учир бага насны хүүхдэд хэцүү байдаг.

СХД-ийн 7-р хорооны иргэн Наранцэцэг

Ялангуяа СХД-ийн 15,16 хорооны нутаг дэвсгэрт амьдарч байгаа хөдөөний иргэдийн хувьд хүүхдээ сургуульд оруулахад их бэрхшээл учирдаг. Тэд хүүхдээ сургуульд оруулахын тулд шан хөлс өгөх, танил тал хайх гэх мэтээр их л бэрхшээл учирдаг тухай ярьж байлаа.

Иргэдээс хэлж байсан дээрх асуудлыг тодруулахаар харъяаллын сургууль болох 86-д очтол манайх гүнзгийрүүлсэн сургалттай тул, шалгалт өгөөд тэнцвэл харъяалал харгалзахгүй авна хэмээх хариултыг өгсөн юм. Гэвч төвөөс алслагдах тутам сургалтын чанар буурдаг өнөөгийн боловсролын тогтолцооны үед тус сургуулийн босгыг давж орно гэдэг асуудал хөдөөгийн хүүхдүүдийн хувьд том асуудал билээ. 82-р сургуулиар ортол сургалт хариуцсан эмэгтэйтэй уулзахыг хүссэн боловч манайх харъяаллын дагуу л авна. Манай ачаалал маш их байгаа хэмээн хэлээд завгүй гэсэн нэрийдлээр ярилцлага өгөхийг хүссэнгүй. Харин 67-р сургуулийн нийгмийн ажилтан Ургац хэмээх эмэгтэйгээс нилээд зүйлийг тодруулж авсан.

Тодруулга:

Манай сургуулийн хувьд 680 хүүхдийн хүчин чадалтай боловч 2380 хүүхэдтэй. Багш нарын өрөөгөө хүртэл анги болгосон. Тэр ч байтугай сургуулийн хонгил, булан тохой бүрийг ашиглаж анги танхим болгоод, зарим ангиа хойд цэцэрлэгт /8анги/ хичээллүүлж байгаа. Өргөтгөл баригдвал бага ангиа тийш нь шилжүүлж арай гайгүй болно. Энэ хичээлийн жилд л гэхэд 329 хүүхэд нэмэгдсэн. Анги дүүргэлт 45-50 болсон. Энэ бүхний эцэст сургалтын чанарын талаар ярих ч хэрэггүй биз дээ. Тэр ч байтугай номын сангаа хүртэл анги болгож, зөөврөөр номоо өгдөг.

Хөдөөний бүртгэлгүй өрхийн хүүхдүүдийн хувьд сургуульд суралцах нь нилээд бэрхшээлтэй асуудал болоод байна. Тиймээс ч тэдний дунд сургуульд завсардалт их байна. Хүүхдүүд сургууль завсардаж байгаа нь өнгөц харахад эцэг эхийнх нь буруу юм шиг байгаа ч төр засаг тэдний өмнө үүрэг хүлээх ёстой. Учир нь нэгэнт хүчин чадлаа 2,3 түүнээс ч олон дахин нугалж ашиглаж байгаа ерөнхий боловсролын сургуулиудыг буруутгах аргагүй.

Тодруулга :

Манай анги 36 хүүхэдтэй, бага ангиудад анги дүүргэлт маш их байдаг. Ахлах ангид орохоор арай гайгүй болдог. Манай анги сургуулийн коридорыг тохижуулсан, тийм болохоор жаахан онцгүй байдаг. Тохь муутай, гэрэл муутай. Бид нарт чөлөөт цагаа өнгөрүүлэх газар байдаггүй. Манай сургууль маш олон хүүхэдтэй болохоор бүх зайгаа анги болгож ашигладаг.

67-р сургуулийн 8г ангийн сурагчидтай хийсэн ярилцлагаас. . .

Тэр ч байтугай тэнд суралцаж байгаа хүүхдүүдийн эрх ашигт ч энэхүү даац хэтрэлт муугаар нөлөөлж, сургалтын чанарыг хотын захын хорооллуудаар буурахад хүргэж байна. Анги дүүргэлт 45-50 байгаа тохиолдолд багш хичээлийн 45 минутад хичээлээ заагаад л гарахаас хүүхэд нэг бүртэй ажиллах боломжгүй болж байна.Тиймээс одоо дээрх ачаалал ихтэй сургуулиудыг өргөтгөх, хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлыг хийх шаардлагатай болж байна.

4. Үл хөдлөх болон хөдлөх херенге

Тус таван хороодоор судалж явах явцад газар эзэмших зөвшөөрөлтэй өрх нийт өрхийн 9.7% буюу 68 өрх л газар эзэмших зөвшөөрөлтэй хэмээн хариулж байлаа. Үлдсэн 633 хөдөөнөөс орж ирсэн бүртгэлгүй өрх хүний эзэмшиж буй газарт эсвэл огт зөвшөөрөлгүй газар бууж амьдарч байна. Ялангуяа СХД-ийн 1-р хорооллын арын дэнжид хөдөө орон нутгаас ирж амьдарч байгаа хүмүүсийн хувьд байдал тун эгзэгтэй байна.

Жишээ:

Бид нарт энэ газрын асуудлыг хурдан шийдэж өгвөл сайн байна. Зарим нь хөөнө, зарим нь гайгүй байж бай л гэх юм. УИХ-ын гишүүн Болормаа саяхан нэг уулзалтан дээр "Ямар ч байсан энэ 5 жилдээ та нарыг хөөхгүй нь" гэж хэлсэн гэнэ лээ. Тэгэхээр тайвшраад ганц байшин босгоё гээд бодох юм. Гэвч хөөгөөд унавал ядарсан хүн байшингаа яах билээ ч гэж бодох л юм.

СХД 15-р хорооны нэгэн иргэний ярианаас

Бусад хороодын хувьд ч гэсэн энэ байдал ажиглагдаж байсан. Тухайлбал УИХ-ын гишүүн Баасанжавын сонгогчидтойгоо хийсэн уулзалтан дээр 7-р хорооны иргэд 38-ын задгайн асуудлыг хэрхэн шийдэх талаар асууж байсан. Гэвч дүүргийн газрын албаны хүн "Тус газар нь СХД-ийн хороодыг цэвэр усаар хангах цогцолбор байгуулах гэээр байрласан, үерийн аюултай газар учраас зөвшөөрөл өгөгдөхгүй" хэмээн хариулсан. Гэтэл тус газар олон айл хашаа хатгаж, байшин барьж амьдарч байгаа. Тус 38-ын задгайд амьдардаг нийт 98 айлын 48 нь хөдөөнөөс орж ирсэн бүртгэлгүй өрхүүд байдаг юм байна. Ер нь судалгаа хийх явцад ажиглагдсан нэг зүйл бол хөдөөнөөс орж ирсэн иргэд ихэвчлэн үер усны аюултай, хот төлөвлөлтөнд тусгагдсан гэх мэт зөвшөөрөл өгөгдөхгүй газруудад бууж амьдарч байгаа тал ажиглагдсан. Эдгээр байдлуудаас дүгнэж хэлэхэд дээрх бүртгэлгүй иргэдийн хувьд "МУ-ын иргэн газар эзэмших эрхтэй" хэмээх Үндсэн хуулийн заалт давхар зөрчигдөж байна.

Хөдөө орон нутгаас орж ирсэн бүртгэлгүй иргэдээс малтай эсэхийг тодруулахад нийт 701 өрхөөс 3 өрх буюу 0.4% нь л цөөн тооны малтай хэмээн хариулсан. Гэвч түүвэр судалгаанд хамрагдсан тус хороодын 104 өрхийн 12.5 хувь буюу 13 өрх хөдөө цөөн тооны малтай гэж хариулсан юм. Энэ нь хороодоос хүн явж судалгаа авахад боломжгүй гэдгээ тодруулах үүднээс цөөн тооны малтай ч түүнийгээ хэлэлгүй үлдсэн байж болох талтай.

Нийт бүртгэлгүй өрхийн 48% буюу 336 өрх хувийн хашаатай, 60% буюу 420 өрх хувийн гэр, байшинтай хэмээн хариулснаас харахад эдгээр өрхийн иргэдийн хувьд амьдрал ямар байгаа нь харагдаж байгаа юм. Хөдөөнөөс нийслэлд нүүж ирж байгаа иргэдийн хувьд гэрээ авчрах нь ялангуяа холын аймгуудын хувьд зардал өндөр учир гэрээ авчралгүй, энд ирж айлын гэр, байшинг гуйж түр хэрэглэх, түрээслэх явдал элбэг байдаг юм байна.

Тодруулга:

Манайх энэ жил Увсаас нүүж ирсэн. Наашаа гэр нүүлгэхэд 300000 төгрөг гэдэг учир тусдаа гарч байгаа хүүгийнхээ гэрийг авчраад, өөрсдийнхөө гэрийг авчирч чадаагүй, тиймээс айлын гэрийг гуйж бариад байж байна. Манайх хөдөлмөрийн чадвартай 5 хүнтэй

ч ажил олдохгүй, хөдөөгийн паспорттой учир ажилд авдаггүй. Амьдрал хэцүү л байна.

СХД-ийн 7-р хорооны иргэн Мөнхбат

Дээрх байдлуудаас дүгнэж хэлэхэд хөдөөний бүртгэлгүй иргэдийн хувьд хөдлөх, үл хөдлөх хөрөнгө эзэмших явдал туйлын хангалтгүй байна. Энэ нь эдгээр өрхүүдийн байдлыг улам хүнд болгож байна. Сүүлийн үед орон сууцны жижүүр хийж, орцонд амьдардаг бүртгэлгүй өрх олширч байна. Хэрвээ жижүүрийн ажлаа хийх боломжгүй болвол эдгээр хүмүүс нь орон гэргүй болоход хүрдэг.

5. ӨРХИЙН ЭМНЭЛЭГ

Бид судалгаанд хамрагдсан хүмүүсээс эмнэлгийн үйлчилгээнд хамрагдаж байгаа эсэх талаар судалгаа авсан юм. Эндээс харахад нийт өрхийн 39.4 хувь буюу 276 өрх эмнэлгийн үйлчилгээнд хамрагддаг хэмээн хариулсан. Гэвч айлуудаар явж судалгаа хийж байх явцад манай иргэдийн эмнэлгийн үйлчилгээнд хамрагдах тухай ойлголтыг зөвхөн амбулаторийн үзлэг төдийхнөөр ойлгодог юм байна. Тиймээс өрхийн эмнэлэгтээ ханиад хүрээд ч юм уу нэг очиж үзүүлснийгээ эмнэлгийн үйлчилгээ авч байна хэмээн хариулж байгаа иргэд ч элбэг байсан. Тэгвэл огт очиж үзүүлээгүй, бүртгүүлээгүй мөртлөө эмнэлгийн үйлчилгээ авдаггүй хэмээн хариулах нэг хэсэг байсан юм. Иргэдээс авсан хариулт нь эдгээр хөдөөнөөс орж ирсэн иргэд эмнэлгийн үйлчилгээг үнэхээр хүртэж чадаж байгаа эсэхийг тодруулахад хангалтгүй байсан учраас хороодын өрхийн эмнэлгийн эмч сувилагч нартай уулзаж ярилцлаа.

Тодруулга:

Бид нар бүртгэлгүй ч гэсэн хөдөөний иргэдэд эмнэлэгт үзүүлэхээс бусад үйлчилгээг үзүүлдэг. Ялангуяа жирэмсэн эмэгтэйчүүд, нярай хүүхдүүд, өндөр настнуудын хувьд бид эргэж тойрч, өрхийн эмнэлгээс үзүүлдэг л үйлчилгээг хийдэг. Яалт ч үгүй яаралтай мэс засал, төрөх, хүүхдийн өвчнөөс бусад тохиолдолд эмнэлэгт хэвтүүлж эмчлүүлэх шаардлага гарч ирэхэд бид туслах ямар ч боломжгүй.

СХД-ийн 6-р хорооны өрхийн эмнэлэг, эмч Сараа

Хороодод цомхон, цэвэрхэн, дулаахан өрхийн эмнэлгийн байрнуудыг төслөөр

барьж өгсөн байлаа. СХД-ийн 7,8-р хорооны нийт 6515 хүнийг хамруулж эмчилгээ, үйлчилгээ үзүүлдэг “Ээлтэй” өрхийн эмнэлгийн эмч ажилтнуудтай уулзаж ярилцлаа. Энэхүү эмнэлэгт нийт 5 эмч, 4 сувилагч, 3

үйлчилгээний ажилчид ажилладаг. Өрхийн эмнэлэг нь дараах төрлийн эмнэлгийн суурь үйлчилгээг үзүүлдэг юм байна. Үүнд:

1. Амбулаторийн үзлэг
2. Идэвхтэй эргэлт
3. Дуудлага
4. Диспансерийн хяналт
5. Урьдчилан сэргийлэх үзлэг
6. Тариа, боолт хийх

Дээрх үйлчилгээг бүртгэлтэй, бүртгэлгүй ялгаагүй үзүүлдэг боловч, эмнэлэгт хэвтүүлж эмчлүүлэх, рашаан сувиллын эрхийн бичгийг хөнгөлөлттэй авах, жирэмсэн, төрсний дараах тэтгэмж авах зэрэгт бүртгэлгүй иргэдийн хувьд хамрагдах боломжгүй байдаг.

Өрхийн эмнэлгийн хувьд гардаг нэг хачирхалтай зүйл бол тэдний төсвийн асуудал байдаг юм байна. Өрхийн эмнэлгийн төсвийг өрхийн суурин хүн амаар тооцож өгдөг бөгөөд дүүрэг, Эрүүл мэндийн нэгдэл, өрхийн эмнэлэг гурвын гурвалсан гэрээнд заагдсан ажлыг үнэлж, дүгнэсний дараа төсвийн хэдэн хувийг өрхийн эмнэлэгт өгөхийг шийддэг ажээ.

Тодруулга:

Өрхийн эмнэлгүүд нь харъяалагдах дүүрэг, Эрүүл мэндийн нэгдэлтэйгээ гурвалсан гэрээ байгуулж, гэрээгээр өгсөн үүргийн биелэлтээр төсвийг олгодог юм байна. Үүнд:

1. 81-100 хувь биелүүлэхэд төсвийн 92 хувь
2. 61-80 хувь биелүүлэхэд төсвийн 72 хувь гэх мэтээр төсвийг шилжүүлдэг.

Ээлтэй эрхийн эмнэлгийн ахлах эмч Д.Оюун

Хорооны бүртгэлгүй иргэдийн зардал төсөвт орж ирдэггүй. Энэ талаар учирдаг бэрхшээлүүдээ өрхийн эмнэлгийнхэн ингэж ярьсан юм. “Бүртгэлгүй иргэд төсөв нэмэгдэхэд нөлөөлөхгүй, хасагдахад шууд нөлөөлдөг. Ялангуяа бүртгэлгүй өрхийн иргэд халдварт өвчнөөр өвчлөх, жирэмсний хяналтад хожуу орох, гэртээ төрөх гэх мэт зүйл гарсан тохиолдолд өрхийн эмнэлгийн ажлын үзүүлэлтийг бууруулах гол хүчин

зүйл болдог. Энэ тохиолдолд төсөвлөгдсөн төсөв 40-50 хувиар буурах ч тохиолдол гардаг”

Ийнхүү өрхийн эмнэлэг нэг талдаа бүртгэлгүй иргэд, нөгөө талдаа дүүргийн шахалтад хэцүү байдалд ордог юм байна.

Тодруулга:

Өөрсдөө ирсэн хүмүүсийг бүртгэж авах, мөн хавар 4 сар, намар 10 сар, өвөл 12 сард хорооныхоо бүх айлаар явж бүртгэл хийдэг. Мөн идэвхтэй эргэлтээр явах үедээ шинэ буусан айл байвал орж бүртгэдэг. Манай иргэд өөрсдийнхөө эрүүл мэндэд муу анхаардаг, болохоо больсон тохиолдолд ирнэ үү гэхээс хир барагтай ирж бүртгүүлдэггүй. Хорооны бүртгэл, өрхийн эмнэлгийн бүртгэл хоорондоо ихэвчлэн зөрдөг.

Ээлтэй өрхийн эмнэлгийн ахлах эмч Д.Оюун

Хэрвээ бүртгэлгүй иргэд мухар олгойн хагалгаанд ороход ЭМД байхгүй бол 45000-50000 төгрөг төлдөг. Гэтэл шилжин ирэх үйлчилгээний хураамжаа ч төлөх боломжгүй иргэдийн хувьд энэ нь дааж давахгүй зардал болж байна. Түр оршин суугчаар бүртгэгдсэн иргэдийн хувьд өрхийн эмнэлэг бичиг хийж өгч хэвтүүлэх тохиолдол байдаг. Бүртгэлгүй иргэдийн хувьд эмнэлгийн үйлчилгээг ийм байдалтай хүртдэг юм байна.

6. Нийслэлд шилжиж ирсэн болон бүртгүүлээгүй шалтгаан

Нийслэлд орж ирсэн шалтгааныг ихэвчлэн ажил хийж амьдралаа сайжруулахаар, ах дүү, хамаатан саднаа бараадаж, оюутны гэр бүл гэх мэт шалтгаан дийлэнх байсан юм. Гэвч зудад малаа алдсан, хөдөө амьдрах аргагүй болж зах зээл бараадаж ирсэн, хүүхдийнхээ ирээдүйг бодож чанартай сургалтад хамруулахаар, эмчлүүлэхээр гэх мэт шалтгаануудыг мөн нилээд хэсэг хүмүүс ярьж байлаа. Ихэнх судалгаанд оролцсон өрхүүд Улаанбаатарыг зах зээл сайтай, яаж ийгээд амьдрах боломжтой учир ирсэн гэж хариулцгаасан.

Нөгөө талаасаа шилжин ирэгсдийн шилжиж ирсэн хугацааг тодруулахад 1 жил хүртэл 289/41.2%/, 1-2 жил болж байгаа 133/19%/, 2 ба түүнээс дээш жил болж байгаа 271/38.6%/, өрх байсан. Эндээс дүгнэж хэлэхэд Улаанбаатарт шилжин ирэгсэд 1 жилийн

дараа гэхэд 50% нь нийслэлийн иргэн болж чаддаг болох нь харагдаж байна. Бүртгүүлээгүй үлдсэн хэсгийн хувьд амьдрал нь улам хүнд болдог.

Тодруулга:

Нийслэлд бүртгэлгүйгээс ажилд авдаггүй, эмнэлэгт үзүүлэх, эмчилгээ хийлгэхэд хүндрэл учирдаг, хүүхдээ сургуульд оруулахад бэрхшээлтэй байдаг гэж түүвэр судалгаанд хамрагдсан 104 өрхийн дийлэнх хүн ам үзэж байсан. Мөн түүнчлэн хогны үйлчилгээ байхгүй, цахилгаангүй, худаг уснаас хол, зарим газар нийтийн ус түгээгүүр байхгүй, хувь хүмүүсийн гараас үнэтэй ус авч уудаг, автобусны буудлаас хол гэх мэт олон бэрхшээлийн талаар ярьж байлаа.

СХД-ийн 6,7,8,15,16-р хорооны 104 айлаас авсан судалгааны дүнгээс. . .

Бүртгүүлээгүй шалтгаанаа ихэвчлэн /453 өрх/ шилжилтийн хураамж төлөх бололцоогүй гэж хариулж байсан. Мөн төлбөрөөс гадна аймаг, сумаасаа шилжүүлэг авч чадаагүй, авахаар хөөцөлдөж чадахгүй нэг хэсэг хүмүүс байлаа. Харин цөөн хэсгийн хувьд /70 өрх/ хаана хандахаа мэдэхгүй, хүнд суртал их, бичиг баримт байхгүй, хөөцөлдөөгүй байгаа, амжаагүй байна /саяхан нүүж ирэгсдийн хувьд/ гэж хариулсан бөгөөд тэр ч байтугай ганц нэг хүн бүртгүүлэх шаардлагагүй гэж хариулсан юм.

ДҮГНЭЛТ

Монгол улсын Үндсэн хуулинд “Түр буюу байнга оршин суух газраа сонгох эрхтэй” хэмээн хуульчилж өгсөн. Гэвч хүн амын хэт төвлөрөл үүсч иргэдэд үйлчлэх үйлчилгээ, байгаль орчин экологийн асуудал, хот төлөвлөлтийн бодлогод учирч байгаа хүндрэлтэй асуудал зэргээс үүдэж нийслэл Улаанбаатар болон хүн ам төвлөрсөн бусад хот, аймгийн төвүүд шилжин ирэгсдээс үйлчилгээний хөлс авах болсон. Улаанбаатар хотын хувьд Нийслэлийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2000 оны 46-р Тогтоолоор шилжин ирэгсдээс авах үйлчилгээний хөлсийг насанд хүрэгчдээс 50000 төгрөг, 18 хүртэлх насны хүүхдээс 25000 төгрөг /өмнө нь насанд хүрэгчдээс 26000төгрөг, хүүхдээс 13000төгрөг/ байхаар тогтоожээ. Энэхүү тогтоол нь Үндсэн хуульд заасан хүний оршин суух газраа сонгох эрхийг хязгаарласан заалт болсон байна.

Дээрх ИТХ-ын тогтоол нь төв суурин газар луу нүүдэллэх нүүдлийг зогсоох оновчтой арга зам биш болох нь эдүгээ нийслэлд зөвшөөрөлгүй, бүртгэлгүй амьдарч байгаа өрхийн тоо баталж байгаа юм. СХД-ийн зөвхөн 5 хороонд л гэхэд нийт суурин

өрхийн ойролцоогоор 10%-тай тэнцэх хэмжээний өрх бүртгэлгүйгээр амьдарч байна. Тиймээс энэ байдлаас гарахын тулд тухайн амьдарч байгаа хөдөө орон нутагт нийгмийн суурь үйлчилгээний тоо, чанарыг нэмэгдүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэх, олон тархай бутархай сумуудыг нэгтгэж, улс орноо бүсчлэн хөгжүүлэх гэх мэт ирээдүйгээ харсан арга замыг сонгон авч хэрэгжүүлэх нь зүйтэй хэмээн бодож байна. Нөгөө талаасаа хотод бүртгэлгүйгээр амьдарч байгаа өрхийн аж амьдрал, тэдэнд тохиолдож буй бэрхшээлийн талаар олон нийтэд дэлгэрэнгүй мэдээлж байх нь хөдөөнөөс хот руу нүүдэллэх нүүдлийн багахан хувийг ч гэсэн зогсоох сайн талтай.

Харин нэгэнт нүүгээд ирсэн, ядуу нэн ядуу амьдралтай өрхүүдийн <увьд тэднийг хотын иргэн болоход бодитой, тодорхой туслалцаа үзүүлэх нь гэдгээр өрхүүдийн аж амьдралыг дээшлүүлэх, нийгмийн асуудлыг шийдэх 'ол арга зам юм. СХД-ийн 5 хорооны бүртгэлгүй өрхүүдийн 14.8%-иар орж ;удалгаа авах явцад ажиглагдсан зүйл бол тэдгээр өрхүүдийн 70 гаруй хувь нь АБДТ-ээс доогуур орлоготой ядуу, нэн ядуу өрхүүд байсан. Тиймээс айлуудаар явж бодит судалгаа хийгээд, үнэхээр амьдрал ядуу шилжин ирэгсдийн үйлчилгээний хөлсийг 100% хөнгөлөх хүртэл арга хэмжээ авах нь ирээдүйгээ харсан зөв арга зам юм. Улаанбаатар хотын хувьд шилжин ирсэн, нийслэлийн иргэн болоогүй өрхүүдийн иргэдийн асуудлыг нэн даруй иийдэхгүй бол дээрх өрхүүдийн иргэдийн хувьд оршин суух газраа сонгох ирэхээс гадна сурч боловсрох, хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалуулах, (ийгмийн хангамж хүртэх, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө эзэмших, эрүүл Июулгүй орчинд амьдрах гэх мэт хүний эрхийн бусад зөрчлүүд бий болж байна. Ийнхүү хэт өндөр төлбөр тавьдгаас иргэд аймгаасаа шилжүүлэг шахгүй ирж, нийгмийн үйлчилгээний зарим тогтолцоонд саад учруулсаар байна. Тухайлбал сургуулийн сурагч нь Улаанбаатарт ирчихээд байхад ургах зардал нь тухайн бүртгэлтэй газар нь үлддэг, өрхийн эмнэлгийн өсөв ч мөн адил ийм замаар шийдэгддэг. Гэтэл бодитойгоор оршиж байгаа азар зардал нь бүртгэлгүйгээс ирдэггүй тул тухайн газраа үйлчилгээгээ хүртэж чадахгүй болж иргэд ч, тухайн ЕБС, өрхийн эмнэлгийн багш, эмч, ажилтнууд ч хохирдог гажуудал үүсч байна.

СХД-ийн дээрх 5 хорооны бүртгэлгүй өрхүүдийн 241 өрх буюу 34.4% цахилгаангүй, 61 өрх /8.7%/-өөс бусад нь шугамын радиогүй гэсэн дүн гарч байна. Гэтэл техник, технологи, мэдээллийн эрин зуунд улсынхаа нийслэлд амьдарч байж, харанхуй, мэдээлэлгүй орчинд амьдарч байгаа дээрх иргэдийн асуудлыг төр засгаас даруйхан шийдэж өгөх явдал нэн чухал байна.

Газар эзэмших зөвшөөрлийн асуудал шат дамжлага, хүнд суртал их, тал тохой татах гэх мэт будлиан ихтэй байгаагаас иргэд зөвшөөрөлгүй газар дураараа бууж, эцэст нь эрх

ашиг нь хохироход хүрч байна. Тиймээс газар эзэмших, ашиглах зөвшөөрөл өгөх журмыг цэгцлэх нь зүйтэй. Учир нь хөдөө орон нутгаас шилжин ирэгсдийн хувьд 10 орчим хувь нь л газар эзэмших зөвшөөрөлтэй, үлдсэн иргэдийн дийлэнх хувь нь зөвшөөрөлгүй газар амьдарч байгаа юм. Төр зөсгийн албан тушаалтнуудын үг яриа, шийдвэр зөрүүтэй байдгаас иргэд зөвшөөрөлгүйгээр хашаа хатгаж, амьдрах явдал ихэсч байна. Тиймээс газар эзэмших, ашиглах асуудалд нэг бодлого баримталж, нэг журмыг мөрдөх нь иргэд хөрөнгө, мөнгөөрөө хохирохгүй байхад их ач холбогдолтой.

Шилжин ирж, зөвшөөрөлгүй амьдарч байгаа өрхүүдийн иргэдийн хувьд тохиолдож байгаа бас нэг бэрхшээл бол хүүхдүүдээ сургуульд хамруулах явдал юм. Гэтэл нийслэлийн ЕБС-иуд, тэр дундаа хотын захын хорооллуудын сургуулиуд хүчин чадал, багтаамжаасаа хэд дахин илүү хүүхэд хамруулан сургаж байгаа билээ. Тиймээс сургуулиудыг өргөтгөх, шинээр сургуулт бариулах ажилд хөрөнгө оруулалт хийх зайлшгүй шаардлагатай байна.

Өрхийн эмнэлгийн хувьд бүртгэлгүй иргэдийг эмчилж, үйлчилж байгаа нөхцөлд ажлын үзүүлэлтийг дүгнэх нэг шалгуур болгож, төсөв мөнгөнийх нь эсуудлыг ч шийдэж өгч байх нь иргэдийн эрх ашиг хохирохгүй байх нэг алхам болох юм.

№	АЙМАГ/ХОРОО	СОНГИНОХАЙРХАН	БАЯНЗҮРХ	БҮГД
1.	Архангай	201	86	287
2.	Баянөлгий	23	5	28
3.	Баянхонгор	137	40	177
4.	Булган	80	23	103
5.	Говь-Аптай	95	67	162
6.	Говьсүмбэр	40	17	57
7.	Дархан-Уул	136	65	201
8.	Дорнод	84	65	149
9.	Дорноговь	33	29	62
10.	Дундговь	99	98	197
11.	Завхан	168	149	317
12.	Орхон	91	51	142
13.	Өвөрхангай	243	122	365
14.	Өмнөговь	31	28	59
15.	Сүхбаатар	32	50	52
16.	Сэлэнгэ	122	68	190
17.	Төв	479	235	714
18.	Увс	109	133	242
19.	Ховд	57	53	110
20.	Хөвсгөл	79	55	134
21.	Хэнтий	78	129	207
	ДҮН	2417	1568	3985

Хороод	Нийт дүн	Үүнээс				Нийт өрх	Үүнээс	
		Суурин	Түр суугаа	Гадаад	Оюутан		Суурин	Түр
1	4562	4461	101			1270	1245	25
2	16398	11001	5397			3866	2750	1116
3	4622	4516	41	65		1259	1249	10
4	7332	7230	6	96		1807	1807	
5	10425	9142	1283			2709	2499	210
6	6229	4172			2057	1163	1163	
7	7362	7185	177			1835	1796	39
8	7569	7392	48	77	52	1858	1848	10
9	7284	6891	393			1804	1722	82
10	6755	6663	84	8		1670	1641	29
11	2640	2349	291			684	587	97
12	6156	5574	367	15	200	1375	1274	101
13	5639	5126	513			1225	1098	127
14	4113	3544	569			950	787	163
15	4394	4278	37	79		1112	1104	8
16	8993	8852	125	16		2085	2058	27
17	7109	6916	193			1697	1646	51
18	7428	7200	190	38		1842	1800	42
19	6574	5111	1456	7		1881	1470	411
20	3735	3412	323			1120	917	203
	135319	121015	11594	401	2309	33212	30461	2751

ИЛТГЭХ ХУУДАС

\ХӨДӨӨ ОРОН НУТГААС НҮҮН ИРЖ ЗӨВШӨӨРӨЛГҮЙ ОРШИН СУУЖ БУЙ ӨРХҮҮДИЙН НИЙГМИЙН АСУУДЛЫН ТАЛААРХ СУДАЛГАА\

Хөдөө орон нутгаас нүүн ирж Нийслэлийн Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт Зөвшөөрөлгүй оршин сууж буй иргэдийн \цаашид зөвшөөрөлгүй оршин суугч гэх\
Талаар хийсэн судалгааны хүрээнд тус дүүргийн 16,17,18,19,20 дугаар хороонуудыг судалгааны энэ хэсэгт хамрууллаа.Лнэгдсэн дүнг хавсралтаас үзнэ үү\

Бүрэн бус мэдээгээр эдгээр хороодод хөдөөнөөс нүүн ирсэн нийт 426 өрхийн 1471 хүн оршин сууж байна.

Ажил эрхлэлт

Дээр дурдсан хороодод зөвшөөрөлгүй оршин суугч хөдөлмөрийн чадвартай 846 хүн байгаагаас зөвхөн 441 хүн буюу нийт хөдөлмөрийн чадвартай хүмүүсийн 5% нь болж байна.Хөдөлмөр эрхлэгч хүн амын тоонд хувиараа хөдөлмөр эрхлэгчид\гутал хувцас оёдог.нүүрс түлээ зардаг.зах дээр тогтмол жижиг наймаа хийдэг г.м-ийг орууллаа\

Хөдөөнөөс нүүж ирэгсдийн хөдөлмөр эрхлэлэтийн хэмжээ ийм бага байгаа нь нэгдүгээртдэдэнд хэдийгээр хөдөө орон нутгаас шилжүүлэг авсан хэдий ч хотод бүртгэл хийлгэх мөнгө байдаггүйгээс хотын иргэн болж ажил хөдөлмөр хийх боломж муутай,хоёрдугаарт мэрэгжил эзэмшээгүйгээс.гуравдугаарт улсын хэмжээнд ажилгүйдэл өндөр байгаагаас,дөрөвдүгээрт олдсон ажил орлого багатай тогтмол бус байдагтай холбоотой байна.

Орлого

Гэр бүлийн хөдөлмөрийн чадвартай гишүүдийн хэн нь ч хөдөлмөр эрхэлдэггүй Байгаа бөгөөд тэд ямарч орлогогүй гэцгээж байлаа.Гэхдээ Баянзүрх дүүргийн 17,19 дүгээр хороонд зөвшөөрөлгүй оршин сууж байгаа иргэдийн амьжиргааны гол эх сурвалж нь техникийн Да хүрээ зах мөн түүхий эдийн Цайз зах дээр цай хоол хийж зарах эсвэл бээлий алчуур зэргийг оёж зарж ахуй амьдралдаа нэмэр болгодог хэдий ч энэ нь туйлын хангалтгүй байна.Мөн 16,18 дугаар хорооны зөвшөөрөлгүй сууж буй иргэд нь ихэвчлэн Нарантуул зах дээр тэрэг түрэх жижиглэнгийн бараа зарах зэргээр амьдралын орлогын эх үүсвэрээ хийж байна. Өндөр настай хөдөөнөөс ирэгсэд нь ихэвчлэн оюутан хүүхдүүдээ бараадан амьдардаг бөгөөд тэд хотын шилжүүлэг паспортгүй учраас хөдөөнөөс тэтгэвэр тэтгэмжээ авахаас гадна энэ нь бас тэр болгон хугацаандаа ирдэггүй

юм байна.

Гэр бүлийн хөдөлмөрийн чадвартай гишүүдийн 1-нь л ажил хийдэг ᠕᠗ өрх байна.Эдгээр өрхүүдийн сарын дундуу орлогыг гэр бүлийн гишүүдэд нь харьцуулахад нэг хүнд ноогдох орлого амьжиргааны баталгаажих доод түвшингээс дунджаар 2 дахин бага байна.

Хөдөлмөрийн чадвартай гишүүдийн 2 болон түүнээс дээш хүн нь ажил хийдэг өрх Байгаа боловч мөн л нэг хүнд ноогдох орлого нь амьжиргааны баталгаажих доод түвшингээс дунджаар 1 дахин бага байна

Хотод амьдрахад наад зах нь хэдэн ширхэг бээлий хийгээд техникийн зах дээр зарахад өдрийн талхны мөнгөтэйгээ залгадаг тийм болохоор өдрийн хоолны мөнгөөрөө тасрахгүй хичээн сайн чанартай хийхийг хичээдэг хөдөө болохоор би хийгээд ч тэрнийг хүн авахгүй шүү дээ мөнгөний боломжтой болохоороо бүртгүүлнэ гэсэн бодол бий

19 хорооны зөвшөөрөлгүй оршин суугч Дорнод аймаг

Сургууль

Судалгаанд хамрагдсан 426 өрхөд сургуулийн насны 272 хүүхэд байгаагийн 267 нь харьяа хорооны сургууль сурдаг бөгөөд үлдсэн 5 хүүхэд сургууль завсардсан байна.

Нэгэнт нийслэлд зөвшөөрөлгүй оршин сууж байгаа тул хүүхдүүдийнх нь сургуулийн асуудалд бас хүндрэл гарч байгаа бөгөөд зарим эцэг эхчүүд учраас хэлэн засаг дарга нартаа ханддаг.зарим нь танил талаа гуйж сургууль/: оруулдаг.зарим нь огт хөөцөлдөхгүй байгаагаас хүүхэд нь сургууль завсарда» явдал гарч байгаа юм байна

Хөдөөнөөс зөвшөөрөлгүй оршин сууж байгаа айлуудын хүүхдүүдийг сургуульд хамруулах талаар нэгдсэн бодлого боловсруулж санал тавихгүй бол өсвөр үе маань бичиг үсэг тайлагдаагүй нэгэн болж өсөхийг үгүйсгэх аргагүй.

18-р хорооны засаг дарга Отгонцэцэг

Эмнэлэг

Хэдийгээр 426 өрхөөс 358 нь эмнэлэгийн үйлчилгээ авдаг гэж хариулсан боловч тэдний зарим нь бид нар нэг их хандаж үзээгүй гэх базарим нь өрхийнхөө эмчийг хааяа гуйж үзүүлдэг гэж байна

Зарим хэсэг нь өвдөж зовох нь ховор гэхдээ өвдлөө ч гэсэн өөрсдийгөө аргалаад

эмчилдэг бөгөөд ер нь энэ хүмүүсийн эрүүл мэндийг судлан эмнэлэгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хэрхэн хамрагдах нь тодорхойгүй байна.

...нэгэнт хүрээд ирсэн өвчтэй хүмүүсийг болон хүүхэд төрүүлэх эмэгтэйчүүдийг бид нар аль болох туслах үүднээс өрөвдөөд түр оршин суугчийн бүртгэл хийгээд эмнэлэгээр үйлчлүүлэх болоцоог хангаж өгдөг

17- р хорооны засаг дарга Балжинням

Харин нэг сайшаалтай тал нь нярай хүүхдийг өрхийн эмч нар нь төрөх газраас мэдээлсний дагуу хяналтанд авч дархлаажуулалт болон эмнэлэгийн үйлчилгээнд хамруулдаг юм байна.

Тэтгэвэр тэтгэмж

Дээрхи хороодод 62 өндөр настан байдгаас 46 тэтгэвэр тэтгэмжээ авдаг гэсэн бөгөөд үүнд хөдөөнөөс тэтгэвэр тэтгэмжээ авдаг хүмүүсийг багтаасан болно.Зарим хүмүүс Хөдөөнөөс ирээд энд хөөцөлддөг боловч шилжүүлэг паспортгүй учраас буцаад хөдөө рүүгээ хүнээр гуйж дайж явуулах чирэгдэл их гардаг юм байна

Эдгээр өндөр настангууд ихэвчлэн оюутан хүүхдээ бараадах болон гадаад дотоодод ажил хийхээр явсан хүүхдүүдийнхээ гэр орныг харах гэж хотод ирдэг бөгөөд түр ххугацаагаар байх болно гээд хөдөө орон нутгаасаа шилжүүлэг бас тэр болгон авдаггүй байна.

Хөдөөнөөс хүүхдүүдээ бараадаж болон гэр орныг сахихаар орж ирсэн насаараа улсад ажилласан ийм хөгшчүүдийн талаар судалгаа гаргаж тэр 50000 төгрөгнөөсөө хөнгөлөх талаар судалмаар байх юмаа

Зөвшөөрөлгүй оршин суугч өндөр настан Ц.Бадрах

Орон сууц

БЗД-ийн 16,18 дугаар хороо нь орон сууцны байшинтай ба 17,19 хорооны зарим хэсэг нь гэр хороололд амьдардаг.

Дээрхи хороонуудын гэр хороололд амьдардаг өрхүүд нь ихэнх нь өөрийн гэрээ авчран нутаг усныхаа танил хүмүүс ,ах дүү нараа бараадан айлын хашаанд буусан байх ба

тгэдгээр айлуудынх нь ихэнх нь газрын зөвшөөрлийг журмын дагуу авсан айлууд байна.

БЗД-ийн 19 хорооны цайззын ар талын ХААИС-ийн байрнууд гэх 1 давхар модон байрууд нь брак хүн амьдарч оршин суух наад захын шаардлага хангахгүй байранд айлууд олноороо амьдарч байна

16,18-р хорооны байрны 83 өрх айлын байранд түрээслэн амьдрах буюу танил айл хамтаатныдаа түр толгой хоргодон амьдарч байна

Дээрхи хороодод 11 өрх байрны 0-ын өрөөнд орцны жижүүр хийн амьдарч байна
Бид 1993 онд хотод орж ирсэн ба ажил хайгаад олдоогүй мөнгө байхгүй болохоор бүртгүүлж хотын иргэн болж чадаагүй тэгээд энэ байранд орцны жижүүр хийн амьдарч байна сардаа 30 хэдэн мянган төгрөгний цалин авдаг Мөнгөтэй болбол бүртгүүлэх сонирхолтой байдаг

17- р хорооны орцны жижүүр Ч.Энхтуяа

Хотод нүүж ирэх болсон шалтгаан

Судалгаанд хамрагдсан 426 өрхийн 334 нь ажил хийж амьдралаа дээшлүүлэхээр,40 нь ах дүү хүүхдээ бараадаж ирсэн гэх.эхнэр нөхөр 2-ийн аль нэг нь оюутан болон ах,эгч,дүү нар нь оюутан тэднийхээ архуй амьдралд туслахаар ирсэн 22 өрх.эмчилгээ үйлчилгээ хийлгэхээр хот бараадаж ирсэн эсвэл ажлын шугамаар шилжин орж ирсэн гэх 24 өрх байна.

Хотод нүүн орж ирсэн айлуудаас БЗД-ийн 20 хороо буюу Гачуурт тосгоны 83 өрхөс бусад нь малгүй иргэд байна.

Шилжин ирснээс хойшхи хугацаа

Дээрхи өрхүүдээс хотод шилжин ирснээс хойш 1 жил болж байгаа өрх 231,нэгээс хоёр жил болж байгаа өрх 110,хоёр ба түүнээс дээш болж байгаа өрх 80 байгаагаас харахад сүүлийн жилүүдэд хотод шилжин суурьших сонирхолтой хүмүүсийн тоо нэмэгдэж байгаа тоо харагдаж байна

САНАЛ ДҮГНЭЛТ

Зөвшөөрөлгүй оршин сууж байгаагаас эдгээр хүн амын эрүүл мэндийн үйлчилгээ авах.сурч боловсрох эрхэд хязгаарлалт тавигдаж байгаа бөгөөд нийгмийн аюулгүй байдал тэднийг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд онцгой анхаарал тавих шаардлагатай байна.

Нийслэлд оршин суух зөвшөөрөл авахад ямар бэрхшээл байгаа талаар судалгаанд

хамрагдсан 426 өрхийн 342 нь мөнгө төгрөгний бололцоо байхгүйгээс болоод бүртгүүлэхгүй байгаа гэх ба зарим өрхүүд нь аймгаасаа шилжүүлэгтэй бөгөөд шилжүүлэг хийлгэх гэхээр олон шат дамжлагатай олон удаа явуулдгаас болоод хүндрэлтэй байгаа талаар дурдаж байгаагаас харахад шилжин суурьшихад төлдөг төлбөрийн хэмжээ олон ам бүлтэй айлд хүндээр тусч байгаа ба энэ талаар холбогдох газруудад санал хүсэлт тавих боломжийн талаар судлах шаардлагатай байна.

Нэгэнт эдгээр айл өрхүүд хөдөө орон нутагт амьдрах болоцоо муу.хот суурин газар бараадаж амьдрал ахуйгаа дээшлүүлье гээд ирсэн болохоор тэдэнд хууль ёсны тэгш эрхийг хангах.Үндсэн хуулиар баталгаажуулсан эрх.бололцоог нь олговол төр хүний эрхийг хүндэтгэж байгаагийн илрэл болно.

Судалгааны эцэст дараах саналуудыг дэвшүүлж байна.Үүнд-

1. Хөдөө орон нутгаас нийслэлд шилжин суурьшихад авдаг нэг удаагийн төлбөрийн хэмжээг нийгмийн анги давхаргад ялгавартай тогтоон зарим нийгмийн бүлэгт хөнгөлөлт үзүүлдэг болох,
2. Хороо хорины нийгмийн ажилтнууд нь дээрхи хүмүүсийн судалгааг гарган түр оршин суугчийн бүртгэлд хамруулан нийгмийн эмзэг бүлэг.гэмт хэрэг зөрчилд өртөмтгий хүмүүсийн судлагааг гарган ямар нэгэн эрх нь зөрчигдөхөөс хамгаалж харьяа цагдаагийн байгууллагатай хамтран ажиллаж байх,
3. Харьяа хороодын зөвшөөрөлгүй сууж буй иргэдээс өндөр настандахир дутуу иргэд.бага насны хүүхдүүдийг дээрхи нэг удаагийн төлбөр авдаг асуудлыг зохицуулах хүртэл хороо хориноос болон ямар нэгэн байгууллагаас зохиогдож байгаа нийгмийн халамжийн ажпуудад оролцуулж байх